Миний тэнгэрлэг мөн чанар ба зорилго

1. Арван хоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Дийтр Ф.Угдорфын доорх мэдэгдлийг уншаад, таныг ямар байгаасай гэж Аврагч хүсдэгийг хайж ол.

Аврагч Есүс Христ Өөрийг нь та нарын хүч чадал гэдгийг ойлгож, мэдэрч, мэдээсэй хэмээн та нараас хүсдэг гэж би боддог. Түүний тусламжтайгаар та нарын гүйцэлдүүлж болох зүйлсэд хязгаар гэж үгүй. Та нарын чадавх хэмжээлшгүй. Тэрээр та нараас өөрсдийгөө Өөрийнх нь мэлмийгээр харахыг хүсдэг. Энэ нь дэлхий та нарыг хардгаас тэс өөр юм.

Аврагч та нарыг Бүхнийг чадагч Бурханы охид, хөвгүүд гэдгийг тодорхой гэгч тунхаглах байсан. Та нарын Тэнгэрлэг Эцэг бол энэ ертөнцийн хамгийн алдар суут, хайр, баяр баясгалан, цэвэр ариун байдал, ариун чанар, гэрэл, ач ивээл, үнэнээр дүүрэн Нэгэн юм. Тэрээр та нарыг Өөрт нь байгаа бүхнийг нэгэн өдөр өвлөн аваасай хэмээн хүсдэг. (Дийтр Ф.Угдорф, "Есүс Христ бол өсвөр үеийнхнийг бат бөх байлгах хүч мөн," *Лиахона*, 2022 оны 11-р сар, 9–12)

Сургаал ба Гэрээ 14:7-г уншаад, Тэнгэрлэг Эцэг танд юу өгөхийг хүсдэг болохыг олж мэд.

2. Залуу эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн асан Мишэлл Д.Крэйг эгчийн доорх мэдэгдлийг уншаад, тэнгэрлэг үнэ цэндээ эргэлзэж буй хүн бүрд өгсөн зөвлөгөөг нь олж мэд.

Бидний тодорхой гэгч харвал зохих хамгаас чухал зүйлс нь Бурханы хэн болохыг мөн өөрсдийгөө үнэхээр хэн гэдгийг, тухайлбал тэнгэрлэг эцэг эхийн "тэнгэрлэг мөн чанартай, мөнхийн хувь заяатай" охид, хөвгүүд гэдгээ харах явдал байж мэднэ [Залуу эмэгтэйчүүдийн уриа, ChurchofJesusChrist.org]. Бурханаас эдгээр үнэнийг өөрт чинь илчлэхийг мөн Тэрээр өөрийн чинь талаар ямар бодолтой байгааг асуу. (Мишэлл Д.Крэйг, "Харах нүд," *2020 оны 10-р сарын Ерөнхий чуулган*, 14)

Сургаал ба Гэрээ 18:10–13-ыг уншаад, Тэнгэрлэг Эцэг таны талаар юу гэж боддогийг олж мэд.

3. Хүүхдийн хэсгийн ерөнхий ерөнхийлөгч Сюзан Х.Портэрийн доорх мэдэгдлийг уншаад, бидний хүн нэг бүр Тэнгэрлэг Эцэг бидний талаар юу гэж боддог талаар яагаад олж мэдэх ёстойг хайж ол.

Бурханы хүүхдийн хувьд та хэрхэн бүрэн дүүрэн хайрлуулдгаа мэдэж, ойлгох үед энэ нь бүхнийг өөрчилдөг. Энэ нь алдаа гаргасан үедээ өөрийнхөө талаар бодох арга замыг тань өөрчилдөг. Энэ нь хэцүү зүйл тохиолдоход мэдрэх мэдрэмжийг тань өөрчилдөг. Энэ нь Бурханы зарлигуудын талаарх үзэл бодлыг тань өөрчилдөг. Энэ нь бусдыг харах өнцөг болон өөрчлөлт гаргах чадварыг тань өөрчилдөг. (Сюзан Х.Портэр, "Бурханы хайр: Бодгальд хамгийн их баясгалант болой," *Лиахона*, 2021 оны 11-р сар, 33)

4. Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсоны доорх мэдэгдлийг уншаад, Тэнгэрлэг Эцэгийн бидний хүн нэг бүрийг юунд хүрээсэй хэмээн найддаг талаар юу гэж зааснаг нь олж мэд.

Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүддээ зориулсан авралын төлөвлөгөө нь бидэнд Түүний амьдарч буй газарт Түүнтэй адил амьдарч, эцэстээ Түүнтэй илүү адилхан болох боломжийг олгоно. "Христийн хамтран залгамжлагчид" болох бидэнд байгаа чадавх зэрэг хамгийн баялаг мөнхийн адислалуудыг Түүний төлөвлөгөө бидэнд боломжтой болгодог" [Ром 8:17]. (Рассэлл М.Нэлсон, "Мөнхийн ач холбогдолтой сонголтууд" [Залуучуудад зориулсан дэлхий даяарх онцгой цугларалт, 2022 оны 5-р сарын 15], broadcasts.ChurchofJesusChrist.org)

© 2024 by Intellectual Reserve, Inc. All rights reserved. PD80007812_363_553-1